

САНАМЖ:

- Эхийг уншаад дараах даалгаврыг 60 минутад багтаан гүйцэтгээрэй.
- Даалгавар бүр 1 оноо.

Өргөс

Гарт өргөс орчхоор тэрүүхэндээ их л шаналгаатайгаар барахгүй тэр дор нь авч хаяхгүй бол улам өвчин орж удалгүй баалж зовоодгийг хэн хүнгүй л мэднэ. Бүдүүн өргөснөөс илүү шаналгаатай нь нарийн өргөс! Сугалаад авах гэхээр гардаггүй тэгсэн мөртлөө өвтгөөд баалуулаад байдаг болохоор нарийн өргөс их хорлонтой болой.

Биед орсон өргөсийг аваад хаячихвал тэр дорхноо зовуурь арилж удалгүй таг мартагддаг. Гэтэл сэтгэлд орсон өргөс гэж бас нэг зовуурьтай юм байдаг нь гарт орсон өргөстэй олон талаар төстэй ажээ. Энэ тухай ярихын тулд биед орсон өргөсөөр зүйрлэн өгүүлж эхлэх маань бас учиртай. Өнөө үед биеийн эрүүл мэндийн тухай их ярих болжээ. Бие махбодод ямар нэг өвчин, хор хөнөөл, хохирол учирсныг бие муудлаа, эрүүл мэнд доройтлоо гэж ярьдаг. Биеийн эрүүл мэнд доройтохын олон төрлийн шинж тэмдгийг хүмүүс сайн мэдэх тул тэр тухай бүрд нь эмч, эмнэлэг бараадаж, бие лагшиндаа засал, тордлого хийлгэдэг. Энэ бол биеийнхээ эрүүл мэндийг хамгаалж байгаа хэрэг. Тэгвэл сэтгэл санааныхаа эрүүл мэндийг бид хэр зэрэг сахиж, хамгаалдаг билээ?

Бараг ярьдаггүй шүү дээ. Хэрвээ эмчид очоод ч юм уу, харьяалах даргадаа “Миний сэтгэлийн эрүүл мэнд муудаад байна. Яах вэ?” гэвэл эмч нь биш гэхэд дарга нь тачигнатал инээд алдан дооглож “За чи больж үз! Сэтгэлийн эрүүл мэнд гэж юу яриад байна аа? Арай солиорч байгаа юм биш биз?” гэж гайхан толгой сэгсэрч тэр хүний үгийг тоглоом тохуу болгож өнгөрөөнө. Ингэж өрөөсгөлдсөнөөс болоод ард олны маань ихэнх хэсэг нь зөвхөн бие махбодын эрүүл мэндийг ярьдаг, боддог тэгэхээрээ өрөөсөн хөлтэй, суга таягтай хүмүүс болон хувирчээ.

“Өргөс” гэхээр манайхны сэтгэлгээнд их сүртэй зүйл орж ирнэ. Гэтэл сэтгэлд шивсэн өргөс буюу “инграм” гэдэг юу болохыг барууны хэвлэлээс ажиглая. Нэг хүн жирэмсэн эхнэртээ: Хараал идмэр! Би чамайг, ахиж бүү үзэгдмэрийг хаях минь. Бурхан өршөөхгүй дээ чамайг! Ялзраад хэвтэж бай” гэж хэлээд хаалга саваад гарчээ. Энэ хэдхэн үгээрээ долоон төрлийн өргөсийг эхнэрийнхээ сэтгэлд шивсэн гэж үзэх онц хүндрэлтэй хэрэгт тооцох ёстой ажээ. Нэгд, хараасан, хоёрт, бүү үзэгд гэж хөөсөн, гуравт, хаяна гэж сүрдүүлсэн, дөрөвт, бурхны нэрээр далайлгасан, тавд, өвчинд нэрвүүлэхийг хүссэн, зургадугаарт, хаалга савж цочирдуулсан, долдугаарт, энэ бүгдийг хэвлий дэх үр нь мэдэрсэн гэж үзээд хувь хүнийг давхар давхар дарамталсан маш ноцтой үзэгдлийн тоонд оруулахуйц бүдүүлэг явдал гэж үздэг ажээ. Манайд бол одоохондоо нохой гахайдаа хүрч, хуц уль гэдэгтээ тулахад л сая хэрэлдэж доромжилж байна гэж үзэх төдий хэмжээнд байна. Настай хүнийг “чи” гэх, нөхөргүй залуу хүүхнийг “авгай” гэх, үр хүүхэдгүй хүнийг “Чи ямар хүүхэдтэй биш”, нөхөргүй хүүхнийг “Чи ямар эр нөхөртэй биш” гэх зэргээр яриандаа халаад санамсаргүй хэлчихсэн үг нь сэтгэлийн шигдээс, өргөс болон хувирч болохыг тооцоолбол үнэндээ манай хүмүүсийн харилцаа нь бие биеийнхээ сэтгэл санааны эрүүл мэндэд тун халтай байгаа билээ. Хагацал үзсэн ажилтан юм уу ажилчиндаа тайтгаруулах зорилгоор 4 хоногийн цалинтай чөлөө өгөх эсвэл гадаадад жуулчлуулах хүртэл хууль АНУ-д байдаг ажээ. Гэтэл монголчууд бид бие биеийнхээ сэтгэлд сэв оруулж, өргөс шаачхаад юу ч болоогүй мэт явдгаасаа болж сэтгэлийн эрүүл мэндээр доройтсоор байна. Үүнийг өөрчлөхийн тулд төрийн дианетик /сэтгэлийн эрүүл мэндийн тухай ухаан/-ийн хөтөлбөрийг нэвтрүүлэх цаг болжээ.

Л.Түдэв 2003

1. Эсээний гол санааг илэрхийлж чадах түлхүүр үгсийг ялгаарай.

А. Өргөс, баалуулж, өвтгөж, зовоодог

- B. Өргөс, сэтгэл, бие, эрүүл мэнд
 C. Өргөс, эмч, өрөөсөн хөл, суга таяг
 D. Өргөс, сэтгэлийн шигдээс, сэтгэлийн сэв, өргөс шаах
2. Эсээнд юуны тухай өгүүлж байна вэ?
 A. Гарт орсон өргөс удалгүй баалж зовоодог тухай
 B. Сэтгэлд орсон өргөсийг сугалаад авч болдоггүй тухай
 C. Бие махбодын эрүүл мэндээ хамгаалж байгаа тухай
 D. Сэтгэлийн эрүүл мэндээ хамгаалахгүй байгаа тухай
3. Эсээний түлхүүр өгүүлбэрийг олоорой.
 A. Бүдүүн өргөснөөс илүү шаналгаатай нь нарийн өргөс!
 B. Сугалаад авах гэхээр гардаггүй тэгсэн мөртлөө өвтгөөд баалуулаад байдаг болохоор нарийн өргөс их хорлонтой болой.
 C. Сэтгэлд орсон өргөс гэж бас нэг зовууртай юм байдаг нь гарт орсон өргөстэй олон талаараа төстэй.
 D. Гарт өргөс орчхоор тэрүүхэндээ их л шаналгаатайгаар барахгүй тэр дор нь авч хаяхгүй бол удалгүй өвчин орж баалж зовоодгийг хэн хүнгүй л мэднэ.
4. Цогцолбор тус бүрд юуны тухай өгүүлснийг зөв харгалзуулаарай.
- | | |
|--|------------------|
| 1.Сэтгэлийн эрүүл мэнд бүх нийтийн асуудал | a. 1-р цогцолбор |
| 2.Сэтгэлийн эрүүл мэнд чухал болох тухай | b. 2-р цогцолбор |
| 3.Өргөс олон янз байдаг тухай | c. 3-р цогцолбор |
| 4.Сэтгэлийн эрүүл мэндийг орхигдуулах нь хөнөөлтэй тухай | d.4-р цогцолбор |
- A. 1d 2b 3c 4a
 B. 1d 2b 3a 4c
 C. 1c 2a 3d 4b
 D. 1b 2a 3b 4d
5. Эхийн тодруулсан цогцолборт юуны тухай өгүүлж байна вэ?
 A. Ард олны ихэнх нь өрөөсөн хөлтэй, суга таягтай байгаа тухай
 B. Сэтгэлийн эрүүл мэндийг үл тоосноос үүдсэн үр дагаврын тухай
 C. Сэтгэлийн эрүүл мэнд бие махбодын эрүүл мэндээс чухал тухай
 D. Ард олны ихэнх нь биеийн эрүүл мэндээ тоохгүй байгаа тухай
6. Тодруулсан цогцолборт зохиогчийн сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн байна вэ?
 A. Ард олны ихэнх нь өрөөсөн хөлтэй, суга таягтай байгаад харамссан.
 B. Сэтгэлийн эрүүл мэндийн тухай ярих нь зөв тухай эргэцүүлсэн.
 C. Монголчуудын ихэнх нь хөгжлийн бэрхшээлтэй байгааг өгүүлсэн.
 D. Сэтгэлийн эрүүл мэндээ сахиж, хамгаалахгүй байгааг шүүмжилсэн.
7. Эхээс санамсаргүй хэлчихсэн үг нь сэтгэлийн шигдээс, өргөс болон хувирч болох баримтыг олж бичнэ үү.
 A. Хараал идмэр! Би чамайг, ахиж бүү үзэгдмэрийг хаях минь.
 B. Нохой гахайдаа хүрч,хуц уль гэдэгтээ тулах
 C. Настай хүнийг “чи” гэх...нөхөргүй хүүхнийг “Чи ямар эр нөхөртэй биш” гэх
 D. ...“Миний сэтгэлийн эрүүл мэнд муудаад байна. Яах вэ?” гэвэл...Арай солиорч байгаа юм биш биз?○○○” гэж гайхна.

8. “...Ингэж өрөөсгөлдсөнөөс болоод ард олны маань ихэнх хэсэг нь зөвхөн бие махбодын эрүүл мэндийг ярьдаг, боддог тэгэхээрээ өрөөсөн хөлтэй, суга таягтай хүмүүс болон хувирчээ.” өгүүлбэрийн онцолсон хэсэгт хэрэглэсэн уран дүрслэлийг тодорхойлоорой.
- A. Ард олны ихэнхийг өрөөсөн хөлтэй, суга таягтай гэж хэтрүүлсэн.
 - B. Сэтгэлийн эрүүл мэндээ орхигдуулж байгааг өрөөсөн хөлтэй, суга таягтай хүнтэй адилтгасан.
 - C. Зөвхөн бие махбодын эрүүл мэндийг боддог өрөөсгөл хандлагыг төлөөлүүлсэн.
 - D. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өрөөсөн хөлтэй, суга таягтай гэж тойруулсан.
9. Үйлийн угсруулан холбох нөхцөлөөр бүтсэн холбоо үгтэй хэсгийг олж тэмдэглээрэй.
- A. шаналгаатайгаар барахгүй, баалуулаад байдаг, сахиж хамгаалдаг
 - B. тордлого хийлгэдэг, өрөөсөн хөлтэй, хэвтэж бай, доройтсоор байна
 - C. нарийн өргөс, хор хөнөөл, эрүүл мэнд, бие лагшин
 - D. очилгүй болохгүй, тооцоолбол халтай, тачигнатал инээх, хүрмэгц дуусна
10. “Гэтэл сэтгэлд орсон өргөс гэж бас нэг зовуурьтай юм байдаг нь гарт орсон өргөстэй олон талаар төстэй ажээ.” өгүүлбэрийн онцолсон гишүүнийг зөв тайлбарласан хэсгийг сонгоорой.
- A. Хоёр өгүүлбэрийг ойролцоо утгаар холбосон зэрэгцүүлэн холбох үг
 - B. Хоёр өгүүлбэрийг эсрэг утгаар холбосон угсруулан холбох үг
 - C. Хоёр өгүүлбэрийг эсрэг утгаар холбосон зэрэгцүүлэн холбох үг
 - D. Өгүүлбэрийн гишүүдийг холбосон дотоод холбоос
11. Зорилгын утгаар холбогдсон угсарсан нийлмэл өгүүлбэрийг тэмдэглээрэй.
- A. Сугалаад авах гэхээр гардаггүй мөртлөө өвтгөөд баалуулаад байдаг.
 - B. Хагацал үзсэн ажилчдаа тайлгаруулах зорилгоор 4 хоногийн цалинтай чөлөө өгдөг.
 - C. Бие лагшиндаа засал тордлого хийлгэхээр эмнэлэг барааддаг.
 - D. Монголчууд бид бие биенийхээ сэтгэлд сэв оруулж, өргөс шаачхаад юу ч болоогүй мэт явдаг.
12. “Гарт өргөс орчхоор тэрүүхэндээ их л шаналгаатайгаар барахгүй тэр дор нь авч хаяхгүй бол улам өвчин орж удалгүй баалж зовоодгийг хэн хүнгүй л мэднэ.” өгүүлбэрийн “баалж” гэсэн үгийн утгыг тайлбарлаарай.
- A. Зэмлэх, зэм хүртээх
 - B. Тохуурхах
 - C. Будаг нэвчих
 - D. Шарх идээлэх
13. “Бие махбодод ямар нэг өвчин, хор хөнөөл, хохирол учирсныг бие муудлаа, эрүүл мэнд доройтлоо гэж ярьдаг.” гэсэн өгүүлбэр дэх тодруулсан хэсэгт хэрэглэсэн таслалын үүргийг тодорхойлно уу?
- A. Угсруулан тоочих утгыг илтгэх
 - B. Зэрэгцсэн олон өгүүлэхүүнийг илтгэх
 - C. Зэрэгцүүлэн тоочих утгыг илтгэх
 - D. Холимог нийлмэл өгүүлбэр болохыг илтгэх

14. “Бүдүүн өргөснөөс илүү шаналгаатай нь нарийн өргөс!” гэсэн өгүүлбэрийг дэлгэрүүлэн хувиргасныг олоорой.
- A. Нарийн өргөс бүдүүн өргөснөөс илүү шаналгаатай.
 - B. Нарийн өргөс шаналгаатай.
 - C. Бүдүүн өргөснөөс илүү зовуурь шаналгаатай нь нарийн өргөс!
 - D. Бүдүүнээс илүү шаналгаатай нь нарийн өргөс юм.
15. Эхээс зохиогчийн үзэл бодол илэрсэн хэсгийг олоорой.
- A. Бурхан өршөөхгүй дээ чамайг! Ялзраад хэвтэж бай” гэж хэлээд хаалга саваад гарчээ.
 - B. Гэтэл монголчууд бид бие биеийнхээ сэтгэлд сэв оруулж, өргөс шаачхаад юу ч болоогүй мэт явдгаасаа болж сэтгэлийн эрүүл мэндээр доройтсоор байна.
 - C. Хагацал үзсэн ажилтан юм уу ажилчиндаа тайтгаруулах зорилгоор 4 хоногийн цалинтай чөлөө өгөх эсвэл гадаадад жуулчлуулах хүртэл хууль АНУ-д байдаг ажээ.
 - D. Бие махбодод ямар нэг өвчин, хор хөнөөл, хохирол учирсныг бие муудлаа, эрүүл мэнд доройтлоо гэж ярьдаг.
16. “Монголчууд бид бие биеийнхээ сэтгэлд сэв оруулж, өргөс шаачхаад юу ч болоогүй мэт явдгаасаа болж сэтгэлийн эрүүл мэндээр доройтсоор байна”- онцолсон үгийг аль хэлцээр солин найруулбал тохирох вэ?
- A. сэтгэл мятаах
 - B. сэтгэлд нь хур буух
 - C. сэтгэл ээдүүлэх
 - D. сэтгэл сэмрэх
17. “ сэтгэл ихэд шаналах, зовох”- гэсэн утгад тохирохгүй хэлцийг олоорой.
- A. дотор өмрөх
 - B. элэг зүрх эмтрэх
 - C. сэтгэл шимшрэх
 - D. сэтгэл мятаах
18. Хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэрийг олоорой.
- A. Сэтгэлд орсон өргөс зовуурьтай.
 - B. Өргөсийг авчихвал дорхноо зовуурь арилна.
 - C. Өргөс оров. .
 - D. Хор хөнөөл, хохирол учирна.
19. “Бие махбодод ямар нэг өвчин, хор хөнөөл, хохирол учирсныг бие муудлаа, эрүүл мэнд доройтлоо гэж ярьдаг” гэсэн өгүүлбэрийн онцолсон гишүүний утга, үүргийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
- A. “Хохирол ” гэдгийг дэлгэрүүлсэн гол дэлгэрүүлэгч
 - B. “ муудлаа, доройтлоо” гэдгийг дэлгэрүүлсэн дэд дэлгэрүүлэгч
 - C. “Учирсныг” гэдгийг дэлгэрүүлсэн захын дэлгэрүүлэгч
 - D. “Эрүүл мэндээ” гэдгийг тодотгосон гол дэлгэрүүлэгч
20. Эхээс “дордох” гэсэн үгтэй ойролцоо утга бүхий өгүүлбэрийг олоорой.
- A. ...Өвтгөөд баалуулаад байдаг болохоор нарийн өргөс их хорлонтой болой.

- В. Бүдүүн өргөснөөс илүү шаналгаатай нь нарийн өргөс!
 С. ...Өвчин орж удалгүй баалж зовоодгийг хэн хүнгүй л мэднэ.
 D. ...Сэтгэлд сэв оруулж, өргөс шаачхаад юу ч болоогүй мэт явдаг.
21. “Гарт өргөс орчхоор тэрүүхэндээ их л шаналгаатайгаар барахгүй тэр дор нь авч хаяхгүй бол улам өвчин орж удалгүй баалж зовоодгийг хэн хүнгүй л мэднэ.” гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгсийг ямар үгээр солин найруулбал оновчтой вэ?
- A. төдийгүй, өвтгөж
 B. үл барам, шаналгаж
 C. төдийгүй, идээрлэн
 D. зогсохгүй, бээрлэн
22. Эхээс найруулгын ерийн зэрэг бүхий бүлэг үгийг олоорой.
- A. Бие махбод, бие лагшин
 B. Эхнэр,авгай
 C. Бие лагшин, засал тордлого
 D. Ярих, хэлэх
23. “Биеийн эрүүл мэнд доройтохын олон төрлийн шинж тэмдгийг хүмүүс сайн мэдэх тул тэр тухай бүрд нь эмч, эмнэлэг бараадаж бие лагшиндаа засал, тордлого хийлгэдэг.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг “махбод” хэмээх үгээр соливол найруулгад ямар өөрчлөлт гарах вэ?
- A. Хүндэтгэлийн найруулга болно.
 B. Ерийн найруулга болно.
 C. Доромж найруулга болно.
 D. Найруулгад өөрчлөлт гарахгүй.
24. Үндэсний бичгээр бичсэн эхийг уншаад зөв хөрвүүлснийг олоорой.
- A. Хэн хүнтэй үг ярина гэдэг
 Хэрэг дээрээ тулалдаан юм.
 B. Гэнэн хүнтэй үг ярина гэдэг
 Хэрэг дээрээ долгилдоон юм.
 C. Хээ хүнтэй үг ярина гэдэг
 Хэрэг тээрээ тулулдаан юм.
 D. Гэнэ хүнтэй өнгө ярина гэдэг
 Гэрэг дээрээ тулалдаан юм.
25. Үндэсний бичгээр бичсэн дараах үгийн бүтцийг зөв задалсныг олоорой

ᠬᠡᠨ ᠬᠡᠨᠲᠡᠢ ᠭᠡ ᠶᠠᠷᠢᠨᠭᠡᠳᠡᠭ
 ᠬᠡᠷᠡᠭ ᠳᠡᠭᠡᠷᠡᠭᠡ ᠲᠤᠯᠠᠯᠳᠠᠭᠠᠨ ᠶᠤᠮᠤ.
 ᠭᠡᠨᠡᠨ ᠬᠡᠨᠲᠡᠢ ᠭᠡ ᠶᠠᠷᠢᠨᠭᠡᠳᠡᠭ
 ᠬᠡᠷᠡᠭ ᠳᠡᠭᠡᠷᠡᠭᠡ ᠳᠣᠯᠭᠢᠯᠳᠣᠨ ᠶᠤᠮᠤ.
 ᠬᠡᠭᠡ ᠬᠡᠨᠲᠡᠢ ᠭᠡ ᠶᠠᠷᠢᠨᠭᠡᠳᠡᠭ
 ᠬᠡᠷᠡᠭ ᠲᠡᠭᠡᠷᠡᠭᠡ ᠲᠤᠯᠤᠯᠤᠳᠠᠭᠠᠨ ᠶᠤᠮᠤ.
 ᠭᠡᠨᠡ ᠬᠡᠨᠲᠡᠢ ᠥᠩᠭᠡ ᠶᠠᠷᠢᠨᠭᠡᠳᠡᠭ
 ᠭᠡᠷᠡᠭ ᠳᠡᠭᠡᠷᠡᠭᠡ ᠲᠤᠯᠠᠯᠳᠠᠭᠠᠨ ᠶᠤᠮᠤ.

ᠶᠢᠯ ᠡᠨᠳᠡᠰ + ᠪᠠᠶᠢᠳᠯᠠᠭᠠᠨ + ᠴᠠᠭᠠᠭᠠᠨ + ᠲᠡᠭᠰᠡᠭᠦᠬᠡ + ᠨᠥᠬᠴᠡᠯ

- A. Үйл үндэс + байдлын дагавар +цагаар төгсгөх нөхцөл
 B. Үйл үндэс + хэвийн дагавар + шаардан захирах нөхцөл
 C. Үйл үндэс + байдлын дагавар +ерөөн хүсэх нөхцөл
 D. Үйл үндэс + хэвийн дагавар + хүндэтгэн захирах нөхцөл

26. “Дөрвөн цаг” шүлгийн хэсгийг уншаад ямар улирал дүрслэгдсэнийг олоорой.

ᠠᠨᠠᠭᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ
ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ
ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ
ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ

- A. Өвөл
- B. Хавар
- C. Зун
- D. Намар

27. Үгсийн дарааллыг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг олж бичээрэй.
барилц, ярилц, хэлэлц,.....

A

B

C

D

ᠪᠠᠷᠢᠯᠴᠢ

ᠶᠠᠷᠢᠯᠴᠢ

ᠬᠡᠯᠡᠯᠴᠢ

ᠬᠡᠯᠡᠯᠴᠢ

28. Шүлгийн хэсгээс уншаад идэр залуус хааш оддогийг олоорой.

ᠠᠨᠠᠭᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ
ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ
ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ
ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨ ᠤᠯᠤᠰᠤ

- A. Алс газар
- B. Сайхан огторгуйн дунд
- C. Нимгэн үүлсийн зүг
- D. Сургуульд

29. Галигаар бичсэнийг үндэсний бичигт зөв хөрвүүлсэн нь аль вэ?

Чинггис хаган Жамух-а-тай хамту йабутал-а богда эзэн-ү мори бүдүрибэсү эзэн морин-у-бан тэригүн-и малий-а-бар дэлэдүн цохигсан.

A

تەنرىن دىنىن دىمىر ، مىن نىيوق
كىھقى ، قىتقىر بىر و يىمىن
قىھقىمىر بىر يىمىر و وىر مىتەر
ن يىيىن ، وىن مىيىقىمىر مىن نىيىمىر ..

B

تەنرىن دىنىن دىمىر ، مىن نىيوق
كىھقى ، قىسقىر بىر و يىمىن
قىھقىمىر بىر يىمىر و وىر مىتەر
ن يىيىن ، وىن مىيىقىمىر مىن نىيىمىر ..

C

تەنرىن دىنىن دىمىر ، مىن نىيوق
كىھقى ، قىتقىر بىر و يىمىن
قىھقىمىر بىر يىمىر و وىر مىتەر
ن يىيىن ، وىن مىيىقىمىر مىن نىيىمىر ..

D

تەنرىن دىنىن دىمىر ، مىن نىيوق
كىھقى ، قىسقىر بىر و يىمىن
قىھقىمىر بىر يىمىر و وىر مىتەر
ن يىيىن ، وىن مىيىقىمىر مىن نىيىمىر ..

30. Дараах үгсийг зөв бичсэнийг олоорой.

болбоос, болмой, үйл дор, бүү эвд

A

- бүү эвд
- болбоос
- болмой
- үйл дор

B

- бүү эвд
- болбоос
- болмой
- үйл дор

C

- бүү эвд
- болбоос
- болмой
- үйл дор

D

- бүү эвд
- болбоос
- болмой
- үйл дор

31. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

A

ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

B

ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

C

ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

D

ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ

32. “ᠠᠨᠠᠨᠠᠨᠠᠨ” үйл язгуурт холбох эгшгийн дүрмээр залгах бүлэг нөхцөл аль нь вэ?

A

- ᠠᠨ
- ᠠᠨ
- ᠠᠨ

B

- ᠠᠨ
- ᠠᠨ
- ᠠᠨ

C

- ᠠᠨ
- ᠠᠨ
- ᠠᠨ

D

- ᠠᠨ
- ᠠᠨ
- ᠠᠨ

33. *ᠠᠨᠠᠭᠤᠨ* ...цэгийн оронд тохирох үгийг сонгоорой

A. суулга

C. памбага

B. суух

D. нямбу

34. Д.Равжаа “4 улирал” шүлгийн

Жаргалтайн дэлгэр зуныхаа сард

Жигдлэн ургасан таван өнгийн бадам найгалзаад

Жигүүртэн олон шувуу нуурын дунд цэнгэхэд

Жавартай өвлийн хүйтнийг мартана.

Захирч сургаагчдын сургаалыг орхиод

Зальхай найман номыг даган явсаар

Завдлагагүй дөрвөн далайн жамыг эс мэдэв л ... гэсэн энэ хэсэгт юуны тухай өгүүлж байна вэ?

A. Зун цаг шиг богино залуу насанд ном сургаалыг эрхэмлэ.

B. Цаг улирлын дулаанд жарган суугаад өвлийн хэцүү цагт зовуузай.

C. Зальхай явдал ямарч сайн зүйлд хүргэхгүй.

D. Жигүүртэн олон шувууд нуурын дунд цэнгэх нь залуу насны бахархал.

35. Шүлэгт байгаа “Зальхай найман ном” гэсэн үг нь ямар хам сэдвийг тодруулж байна вэ?

A. Нийгмийн хам сэдэв

C. Түүхийн хам сэдэв

B. Шашны хам сэдэв

D. Намтрын хам сэдэв

36. МНТ зохиолын Алунгоо эхийн домогт эв эеийг хичээхийг сургасан нь юунаас улбаатай вэ?

A. Добу мэргэн үгүй болсноос

B. Цэгээн шар хүн өрхний завсраар орж ирснээс

C. Хөвгүүдийн далд хэлэлцсэнээс

D. Багласан 5 мөс хугалуулснаас

37. МНТ зохиолд Бодончар урагт эс тооцогдон, Балжийн аралд хүрч, өвсөн эмбүүл барьж ганцаар амьдрах болсон. Түүний ахуй амьдрал нь дэвжин дээшлэхэд юу нөлөөлсөн бэ?

A. Хар хур шувууг барьж ханьтай болсноор

B. Буха Хатаги ах нь дүүгээ нэхэн ирснээр

C. Бүлэг иргэнийг олзолж авснаар

D. Бие даан сэтгэн бодох, амь зуух чадвар нь сайжирснаар

38. Дараах жишээнээс хэтрүүллийн уран дүрслэлд тохирохыг олоорой.

A. Хөрст дэлхий хөрвөж

Хөвчин улс хямралдаж

Хөнжилдөө унтах завгүй

Хөнөөлдөн тэмцэж байв.

B. Оюунтай төрсөн Өэлүн эх

Оёдолт дээлийг огшуулан өмсөж

Олирс мойлыг түүж явж

Өчүүхэн хөвгүүдээ хайрлан тэжээж...

C. Хар хэрээ халтар нугасыг барих болов.

Харц боол хаан эзэндээ халдах болов.

D. Солонго мэт сонсох

Соргог Хуагчины

Сонорын хүчээр...

39. “Бодончар богд” өгүүллэгийн ...Бүлэг иргэний хүрээнд бууж гэдсээ цайлгасан Бодончар “гэр сууцруугаа очиж сэтгэлээ цайлгах минь” гэж орогшин хул мориндоо хэлээд мордоно... энэ хэсэгт “цайлгах” гэдэг үгийн утга хэрхэн шилжсэнийг зөв тодорхойлсныг олоорой.

A. Айраг цагаа ууж гэдсэндээ хоолтой болсныг, ганцаараа байж сайн сайхан зүйл бодож хүсэхийг хэлжээ.

B. Дандаа мах идэж байгаад сая цагаан идээ идэж уусныг, цагаан цайлган сэтгэлтэй болсныг хэлжээ.

C. Гэдсээ цагаан идээгээр дүүргээд, сэтгэлээ цагаан бодлоор дүүргэхийг хэлжээ.

D. Гэдэс нь цагаан өнгөтэй болохыг, сэтгэл нь хар буруу санаагүй болсныг хэлжээ.

40. Орогшин хул морины дүр дүрслэл бүхий хэсгээс Бодончар түүнээс өөр ханьгүй гэдгийг баталсан жишээ аль вэ?

A. Бодончар морио зүдрээчих вий гэж чонон шогшоогоор шогшсоор мөр зүгээ бага зэрэг буруулсхийн дөлсөөр, эмбүүл сууцнаа ирнэ.

B. Мөнөөх бүлэг иргэн гол дайрт, годил сүүлт орогшин хул морьтой, эр бор харцага барьсан хорь гаруйхан настай, идэрмэг сэргэлэн үг яриатай залуу эрийг ихэд сонирхоно.

C. Олон сүргийн дундаас зүс буруу гэж энэ муу гол дайрт годил сүүлт орогшин хул морийг ах нар маань өгсөн юм.

D. Орогшин хул морь нь хэрэмний чих шиг урт шар хялгастай, бор улаан, ягаавтар зүс холилдсон үзэмжит урт чихээ солбиулан “За ойлгож байна аа эзэн богд минь” гэх шиг ялаархан, хазаар дарна.